

НИЙСЛЭЛИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тус газраас 2019 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөө, дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хуульд заасан улсын бүртгэлийн зарим төрлийн үйлчилгээг үзүүлэх гэсэн 2 үндсэн чиг үүргийн хүрээнд Захиргааны хэлтэс /17/, Бүртгэлийн хэлтэс /38/, Харилцагчийн үйлчилгээний хэлтэс /2/, Архивын хэлтэс /10/, Дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтэс /308/ гэсэн нэгжүүдтэйгээр нийт 375 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүллээ.

Нэг. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

2019 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын 5 тогтоолын 16 заалт, Засгийн газрын хуралдааны 4 тэмдэглэлийн 23 заалт, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны 2 тэмдэглэл 4 заалт, нийт 11 шийдвэрийн 43 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллалаа. Эдгээрээс тайлант хугацааны зорилтод бүрэн хэрэгжсэн 41, хэрэгжих шатандаа байгаа буюу 70%-ийн хэрэгжилттэй 2 байгаа бөгөөд хэрэгжилт 98.53%-тай байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалтын хэрэгжилт:

1.1. Тайлангийн хугацаанд Нийслэлийн удирдах ажилтны зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 18 удаа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын Зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг 2 удаа хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн 7 үүрэг чиглэлийг хүлээн авч, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллалаа.

1.2. Газрын 2019 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2019 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөнд тусгах саналыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт, газрын Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Монгол Улсын болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус батлуулахаар хүргүүлэн ажиллалаа.

Нийслэлийн хэмжээнд 97 наснаас дээш өндөр настны судалгааг гарган, иргэний улсын мэдээллийн цахим санд нягтлан шалгаж, 2019 оны 01 дүгээр сарын 09-нд ИУБГазарт хүргүүлсэн.

Иргэний улсын бүртгэлийн лавлагаа олгох эрх бүхий албан хаагчийн нэрс болон "Нууцын баталгаа"-г нийслэлийн хэмжээнд нэгтгэн гаргаж Иргэний улсын бүртгэлийн газар болон Тамгын газарт хүргүүлж ажилласан.

Бүртгэлийн багц хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилгоор одоо мөрдөгдөж буй зарим дүрэм журмуудад санал хүргүүлэн ажилласан. Тухайлбал:

- ✓ “Төлбөрийн чадваргүйдлийн тухай” хууль;
- ✓ “Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай” хууль;
- ✓ Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартад оруулах санал;
- ✓ “Улсын бүртгэлийн багц хууль болон иргэний улсын бүртгэлийн журмуудыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, санал;

- ✓ Иргэний улсын бүртгэлийн онлайн болон оффлайн системийг хөгжүүлэхэд өгөх санал;
- ✓ Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулга түүнтэй холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах журам;
- ✓ “Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ашгийн зорилгоор нийтийн байрыг хөлслөх үйлчилгээ эрхлэхэд дагаж мөрдөх нийтлэг журам”;
- ✓ Иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 5 дугаар зүйлд заасан түр оршин суугчийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тоо мэдээг гаргах маятын загварт
- ✓ Албан тушаалын тодорхойлолтод 1 удаа,
- ✓ Хороо шинээр байгуулагдахтай холбоотойгоор 2 удаа тус тус санал нэгтгэн хүргүүлсэн.

Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд дэх Улсын бүртгэлийн үйлчилгээний ажлын ачаалал, үйлчилгээний стандарт, тулгамдаж буй асуудлыг судлан, авах арга хэмжээний санал боловсруулан удирдлагад танилцуулсан.

1.1. Хяналт шалгалтын ажлын хүрээнд:

Тайлангийн хугацаанд төлөвлөгөөт шалгалт 8, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 28, өргөдөл санал гомдлын мөрөөр 887 шалгалт, нийт 923 шалгалт хийсэн байна.

2019 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар иргэний бүртгэлийн чиглэлээр 58487 бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 9707 бүртгэлд, хуулийн этгээдийн чиглэлээр 101 бүртгэлд, архивын чиглэлээр 2503 нийт 70798 бүртгэлд байнгын хяналт тавьж, 1281 зөрчил илрүүлэн, хяналтын улсын байцаагчийн 1483 дүгнэлт гарч, 22765 иргэн, хуулийн этгээдэд нийтдээ 623345000 /зургаан зуун хорин гурван мянга гурван зуун дөчин таван мянга/ төгрөгийн торгууль ногдуулсан байна.

1.2. Бүртгэлийн ажлын чиглэлээр:

✓ Нийслэлийн хэмжээнд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 734472 иргэнд иргэний бүртгэлийн үйлчилгээг газар, 9 дүүрэг болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдүүдээр хүргэн ажилласан байна. Үүнд:

- ❖ Төрсний бүртгэл-33642
- ❖ Гэрлэлтийн бүртгэл-10137
- ❖ Гэрлэлт цуцлалтын бүртгэл-2326
- ❖ Үрчлэлтийн бүртгэл-605
- ❖ Овог нэр өөрчлөлтийн бүртгэл-1858
- ❖ Эцэг тогтоолтын бүртгэл-1553
- ❖ Нас баралтын бүртгэл-7423
- ❖ Засвар өөрчлөлт-347
- ❖ Дахин олгосон гэрчилгээ-10420
- ❖ Хөдөө орон нутгаас шилжин ирсэн-10560
- ❖ Хот доторх шилжилт хөдөлгөөн-103174
- ❖ Иргэний үнэмлэх олголт-109131
- ❖ Үндэсний энгийн гадаад паспорт олголт-264574
- ❖ Лавлагаа олголт-178722

Иргэний улсын бүртгэлийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Үндэсний энгийн гадаад паспортад орсон өөрчлөлтүүдийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв болон дүүргүүдийн улсын бүртгэлийн хэлтсүүд вейб сайт болон мэдээллийн самбаруудад байршуулан ажиллаж байна. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Драгон төв нь бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан гадаад паспорт болон иргэний үнэмлэх байршуулах хайрцагийг шинээр хийж, олголтын цонхонд байршуулснаар улсын бүртгэгчийн ажлын бүтээмж дээшилж, иргэдэд

илүү хүртээмжтэй болсон байна.

Иргэний цахим үнэмлэхийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн онлайнаар захиалах болсон. 2019 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 568 иргэн иргэний үнэмлэхээ онлайнаар захиалсан байна. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар үйлчилгээний ачаалал ихтэй Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст 1 ширхэг, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Дүнжингарав төвд КИОСК машиныг байрлуулан 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны хооронд 29543 иргэнд үйлчилгээг киоск машинаар үзүүлсэн байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар Сангийн яамтай хамтран “Цахим төлбөрийн баримтын систем” /e-barimt/ аппликейшныг ашиглан иргэний улсын бүртгэлийн лавлагаа, иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээ, хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн хураамж зэрэг 105 төрлийн улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх боломж бий болсон. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн дэх Улсын бүртгэлийн газрын даргын 2019 оны А/36 дугаар тушаал гарч, “Цахим төлбөрийн баримтын систем” /e-barimt/ аппликейшныг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог төлөх боломж бий болсон талаарх мэдээлэл, зөвлөгөөг үйлчилгээний цанх, мэдээллийн самбар болон цахим хуудсанд шинэчлэн байршуулж, үйлчлүүлж буй иргэн бүрт мэдээлэл хүргэн ажиллахыг үүрэг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар Цахимаар 568 иргэн , Гэрэгэ киоск-29543 иргэн, Төрийн төлбөр тооцооны И баримт апплейкшнээр 1442 иргэн нийт 31553 иргэн үйлчилгээ авсан байна.

Тайлант хугацаанд “Улаанбаатар Буян” ХХК-ний байранд 2019 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар /өссөн дүнгээр/ нийт 7423 бүртгэл хийгдсэний 6629 нас барсны бүртгэл “Улаанбаатар Буян”-д бүртгэгдэж, 794 нас барсны бүртгэл нь нийслэлийн 9 дүүрэгт бүртгэгдсэн байна. Мөн Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, дүн шинжилгээ, судалгааны хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу нийслэлийн хэмжээнд амиа хорлож нас барсан иргэдийн судалгааг 2017-2019 оны 04 дүгээр сарын байдлаар гарган хүргүүлэв.

✓ Нийслэлийн хэмжээнд Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн тоон мэдээ 2019 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар /өссөн дүнгээр/ **198087** мэдүүлэг хүлээн авч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд:

- 1.Анхны бүртгэл-22649
- 2.Өмчлөх эрх шилжих гэрээ-37077
- 3.Барьцааны гэрээ-120399
- 4.Бусад гэрээ-703
- 5.Бүртгэлд өөрчлөлт оруулах-4240
- 6.Лавлагаа, хуулбар-12078
- 7.Урьдчилсан тэмдэглэл-941

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 8600 гаруй гарын авлага материал бэлтгэн иргэдэд хүргэж ажилласан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-ийн шинэчилсэн хувилбар /EPRsv2/-ыг хүлээн авах бэлтгэл ажлыг хангах, системийг тестлэх зорилгоор 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 09-ний хооронд дүүрэг дэх УБХ-ийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч хуваарийн дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт програмын сургалтанд хамрагдсан.

Тус хэлтэс нь НҮНТөвүүдэд бүртгэгдсэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг дүүргийн бүртгэлийн хэлтсүүдэд хүргэх хуваарийг хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Батлагдсан хуваарийн дагуу улсын бүртгэгч нар эд хөрөнгийн

эрхийн улсын бүртгэлийн хувийн хэргийг бүртгэлийн дугаар тус бүрээр холбогдох дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст нийт 58504 ширхэг бүртгэлийн эх нотлох баримтыг хүлээлгэн өгч, хүлээлцсэн бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зурж баталгаажуулан авч ажилласан байна.

✓ Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлээр нийт 128 бүртгэл хийгдэж, тэмтэгтийн хураамж 2,638,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- ❖ Шинээр үүсгэн байгуулсан – 58
- ❖ Нэмэлт өөрчлөлт оруулсан – 66
- ❖ Хуулийн этгээдийн лавлагаа - 4

Төрийн үйлчилгээг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээний шат дамжлага, төвлөрлийг сааруулах чиглэлээр “100 айл” дахь УБЕГ-ын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт үзүүлдэг байсан үйлчилгээг 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд шилжүүлээд байна.

Дээрхи ажлын хүрээнд тус хэлтэс нь Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллах улсын бүртгэгчдийн үйлчилгээ үзүүлэх цонхийг гаргаж бэлэн болгосон. Өнөөдрийн байдлаар Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил төвүүдэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.

✓ Архивын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил;

- ❖ Иргэнд олгосон лавлагаа – 144292
- ❖ Хуулийн этгээдэд - 40810 нийт 185102 лавлагаа олгосон.
- ❖ Нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримт –351690
- ❖ Орон нутагт хүргүүлсэн баримт -11315
- ❖ Баримт ашиглалт -3684
- ❖ Сэлбэн зассан баримт- 167
- ❖ Архивт байрлуулсан баримт –403106
- ❖ Он цагийн дараалалд оруулсан баримт –134669 нийт 1089733 баримтанд архивын ажил хийгдсэн байна.

Хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Баярцэцэг БЗД –ын 15 дугаар хорооны улсын бүртгэгч М.Цэндсүрэн, ЧД-ын 13 дугаар хорооны улсын бүртгэгч Х.Бүргэдбаатар, БНД-ын улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Г.Оюунбилэг, БХД-ын улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч М.Ариунбаяр нарт иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа хэрхэн олгох, “Мэдээлэл удирдах програм” дээр ажиллах талаар ажлын байран дээр сургалт явуулсан ба НҮНТөвүүд, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн чиглэлээр лавлагаа олгож байгаа хороо, дүүргийн улсын бүртгэгч нартай утсаар холбогдож, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрт нь өгч байна.

Салбарын Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссын 2018 оны 01 дүгээр шийдвэрээр хадгалах хугацаа дууссан баримтыг устгах тухай Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/02 дугаар тушаалаар архивын хадгалах хугацаа дууссан баримтыг устгах ажлын хэсгийн бүрэлдхүүн, устгах ажлын хуваарийг батлан, 2019 оны 3 дугаар сарын 04-07-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Үүнд:

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичиг 475344 хуудас бүхий 2787,1 кг 14 төрлийн баримтыг устгасан.

БНШАЗК-ын 2018 оны 1-р шийдвэрээр иргэний гэр бүлийн байдлын бүртгэл хийхэд бүрдүүлсэн баримт бичиг 5 хадгаламжийн нэгж /хн/ /1665 хуудас/ бүхий 6.4 кг; иргэний паспорт, үнэмлэх, цахим иргэний үнэмлэх авахад бүрдүүлсэн материал 17 хн /4399 хуудас/, 34.1 кг; иргэний паспорт, үнэмлэх, цахим иргэний үнэмлэхний дахин олголтын анкет 134 хн /36378 хуудас/ 268 кг; иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн баримт ИУБ-22 маягт 238385 ширхэг, 1270.5 кг; иргэний үнэмлэх дахин олголтын журнал 134 хн, /3851

хуудас/ 27.8 кг; ИГБББ-ийн лавлагааг үндэслэн гэрчилгээ олгосон бүртгэлийн дэвтэр 117 хн /27143 хуудас/ 219.5 кг; иргэний паспорт, иргэний үнэмлэх, цахим иргэний үнэмлэхний талаарх тодорхойлолт олгосон тухай бүртгэлийн дэвтэр 46 хн /1154 хуудас/ 8 кг; ИУБ-21 маягт 117009 ширхэг, 652.7 кг; хүчингүй болсон иргэний баримт бичиг /гадаад паспорт, иргэний үнэмлэх, иргэний цахим үнэмлэх, буцах үнэмлэх, төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа / 3066 ширхэг, 15.2 кг; иргэний бүртгэлийн баримтыг архивт хүлээлгэн өгсөн тухай дагалдах хуудас 102 хн, /18493 хуудас/ 102.1 кг; иргэний шилжин суухыг хүссэн өргөдөл 15 хн, /3931 хуудас/ 30 кг; ИГБББ-ийн лавлагаа 20 хн, /6209 ширхэг/ 29.2 кг; үл хөдлөх эрхийн бүртгэлийн хувийн хэргийг архиваас түр олгох бүртгэлийн дэвтэр 72 хн, /7150 хуудас/ 45.4 кг; үл хөдлөх эрхийн бүртгэлийн захиалгын хуудас 42 хн, /9654 хуудас/ 71.9 кг бүхий 14 төрлийн баримтыг устгасан.

Ажлын хэсгийнхэн Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны харьяа "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар", Багануур дүүргийн дулааны цахилгаан станц, Багахангай дүүргийн "Илч орд" нийслэлийн өмчит улсын үйлдвэрийн газар, Налайх дүүргийн "Чандмань- Налайх" ОНӨААТГ-ай тус тус хамтран зохион байгуулсан.



Нийслэлийн улсын бүртгэлийн газар, 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс устгалын ажлыг зохион байгуулсан тухай илтгэх хуудас, устгалын акт, устгалын ажлыг баримтжуулсан зургийг дэлгэрэнгүй байдлаар тус тус ирүүлсэн болно.

Архивын сан хөмрөгийн хадгалалт, хамгаалтын талаар авч хэрэгжүүлсэн ажил:

- Иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтын архивын сан хөмрөг №4-ыг 2019 оны 1 дүгээр сард Улсын бүртгэлийн ерөнхий газраас 4 сейф бүхий 56 нягтруулсан шүүгээг хүлээн авч хурлын заал байсан 66м² талбайд угсруулан байрлуулж, 1989-2018 оны иргэний улсын бүртгэл хөтлөхөд бүрдүүлсэн эх нотлох баримтуудыг он цагийн хязгаараар, дүүрэг тус бүрээр төрөлжүүлэн хамгаалалтын хайрцганд хийж, данс бүртгэлийг давхар хөтлөн ажиллаж байна.



Одоогоор 1989-2016 онуудын иргэний улсын бүртгэлийн эх нотлох 4500 гаруй баримтад 2909 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэн байрлуулаад байна.



1.4 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

2019 оны 01 дүгээр улиралд төсөвт төвлөрүүлсэн орлого:

№	Хугацаа	Орлого, зардлын зүйл анги	Үйлчилгээний төрөл	Мөнгөн дүн /өссөн дүнгээр/
1	2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар	Улсын төсөвт	Үйлчилгээний орлого	9,7 тэр бум төгрөг
2	Орон нутгийн төсөв	Торгууль шийтгэврийн орлого		694,7 сая төгрөг
Нийт 10,4 тэр бум төгрөг буюу төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн.				

Орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлж өртөгийг тайлант хугацаанд нь шингээж оруулсан. Мөн нийт орлогыг тухайн тайлангийн хугацааны урьдчилж орсон гэсэн хэлбэрээр салгаж үйл ажиллагааны ашгийг зөв тодорхойлж ажилласан.

Ажилтнуудын цагийн бүртгэлд хяналт тавьж хариуцсан хэлтсийн даргаар цагийн тодорхойлолт гаргуулж цалинг тогтмол хугацаанд олгосон. Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог сар бүр тогтмол хийж тайланг хугацаанд нь өгсөн.

Сар бүр эд хариуцагч нарын үнэт цаасны бар код, санхүүгийн тооцоог шалган хүлээн авч тайланд тусгаж ажиллаж байна.

- Анхан шатны баримтанд үндэслэн бараа материалын хөдөлгөөн хийж, сар бүр тайлагнасан. Үнэт цаас давхардсан тоогоор 1227211 ширхэг нийт 259299234 төгрөгний орлого авч 749646 ширхэг нийт 733645301 төгрөгний түгээлт хийсэн. Бичиг хэргийн материал давхардсан тоогоор нийт 150828646 төгрөгний 89484 нэр төрлийн орлого авч нийт 147237176 төгрөгний 87418 ширхэг бичиг хэргийн материал зарлагдсан. Аж ахуйн материал нийт 13056644 төгрөгний 1250 ширхэг орлого авч, нийт 8414404 төгрөгний 1237 ширхэг нэр төрлийн материал хүлээлгэн өгсөн. Сэлбэг хэрэгсэл нийт 2969000 төгрөгний материал авч хүлээлгэн өгсөн. Түлш шатах тослох материал нийт 9400000 төгрөгний шатахуун авч 9550000 төгрөгний шатахуун олгосон санхүүгийн тайланд үнэн зөв тусган байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэсэн.

- Нийслэлийн улсын бүртгэлийн газрын нийт хэлтэс, нэгжүүдийн 2019 оны 01-р сарын 02-ноос 2019 оны 06-р сарын 30-нийг хүртэлх хугацаанд бүртгэлийн үйл ажиллагааны явцад техникийн алдаанаас 2548, улсын бүртгэгчийн алдаанаас 1188 ашиглагдахаа больсон нийт 3736 ширхэг үнэт цаасыг төрөл, хэлтэс, нэгж тус бүрээр танилцуулж газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гарсны дагуу газрын даргын тушаалаар устгалд оруулсан.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас нийт 64,671,536.6 өртөгтэй, 11,854,852.02 төгрөгний хуримтлагдсан элэгдэлтэй 77 ширхэг үндсэн хөрөнгө, Азийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 24,552,000 төгрөгний өртөгтэй 56 ширхэг үндсэн хөрөнгө, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар 15 сая төгрөгний өртөгтэй суудлын авто машин хүлээн авч эд хариуцагч нарт хүлээлгэн өгсөн.

- Нийслэлийн засаг даргын хөрөнгө оруулалтаар нийт 62,700,000 төгрөгний 48 ширхэг үндсэн хөрөнгийг орлогод бүртгэн авч хүлээлгэн өгөхөд бэлэн болсон.УБЕГ-ын санхүүгээс нийт 20 нэр төрлийн 36335 ширхэг үнэт цаас татан авч үүнээс 645532 ширхэг үнэт цаасыг газар, 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн улсын бүртгэгч нарт хувиарласан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээлэл байрлуулах зөвлөмжийн дагуу сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, тайлбар, тушаал шийдвэрийг цаг тухай бүрд оруулж ажилласан. 2019 онд нийт 122 мэдээлэл оруулахаас 122 мэдээлэл оруулж, Сангийн яамны цахим хуудсанд гэмтэл гарсаны улмаас PDF файлаар мэдээлэл оруулах боломжгүй болсон тул 1 мэдээлэл хугацаа хоцорсон. Тухайн үед Сангийн яамны шилэн данс хариуцсан мэргэжилтэнтэй 2 удаа утсаар холбогдон мэдэгдсэн болно. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл:

- Тухай бүрт оруулвал зохих 80 мэдээллээс оруулсан 80;
- Сар бүр оруулвал зохих 30 мэдээллээс оруулсан 30;
- Улирал бүр оруулвал зохих 3 мэдээллээс оруулсан 3;
- Хагас жилээр оруулвал зохих 4 мэдээллээс оруулсан 4;

Бүтэн жилээр оруулах 5 мэдээллээс оруулсан 5 нийт 122 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж, шилэн дансанд байршуулаагүй мэдээлэл байхгүй болно.

1.5. Албан хэрэг хөтлөлтийн талаар:

Баримт бичгийн шийдвэрлэлт болон бусад мэдээллийн эрэлт хайлтыг шуурхай болгох үүднээс газарт ирсэн баримт бичгийг “Албан хэрэг хөтлөлтийн E-DOC програм”-д бүртгэн компьютерийн санамжид оруулан ажиллалаа. Тайлангийн хугацаанд нийслэлийн хэмжээнд 17968 албан бичиг хүлээн авч бүртгэснээс 11095 нь хариутай бичиг байх ба 11051 албан бичгийг шийдвэрлэж хугацаа болоогүй 44 албан бичиг шийдвэрлэлтийн шатандаа байна. Мөн хугацаанд 11548 баримт бичгийн төслийг ажилтнуудаас хүлээн авч удирдлагаар баталгаажуулан хэвлэмэл хуудсан дээр буулган албажуулан, нэгдсэн дугаар олгож хаяглан холбогдох газарт нь хүргүүлсэн

1.6. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын мэдээ:

Цахим өргөдөл, гомдлын програм /egr.ulaanbaatar.mn/-ыг ашиглан, Засгийн газрын 11-11 төв, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, Шуурхай удирдлага, зохицуулалтын төв, www.ub1200.mn цахим хуудас, smart UB, Clean UB аппликейшн, 1800-1200, бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 тусгай дугаарын утас болон УБЕГ-ын болон тус газрын веб хуудас, хэлтэс нэгжүүдийн ажлын байр, иргэдээс санал хүсэлт авах хайрцаг, дэвтэр зэрэг 12 эх сурвалжаар иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг чирэгдэлгүй шуурхай хүлээн авч, шийдвэрлэн ажиллалаа. Тайлангийн хугацаанд нийт 287 өргөдөл, хүсэлт хүлээн авснаас:

1. Хүсэлт-106

2. Гомдол-167
3. Талархал-14 байна.

Мөн хүний нөөцтэй холбоотой гаргасан 20, үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хяналтын улсын байцаагчид гаргасан нийт 887 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн. Тус газрын өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувь, шийдвэрлэлтийн хугацаа 7 хоног, 4 цаг, 6 минут. Энэ нь нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас 2 хоногоор шуурхай шийдвэрлэсэн үзүүлэлттэй байна.

Мөн газрын 7777-1890 дугаарын утсаар 12 иргэнээс санал, хүсэлт хүлээн авч ажилласан ба үйлчилгээний ачаалал, ажлын байрны зохион байгуулалтын талаар ирүүлсэн гомдлын дагуу 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Оргил төвд хүний нөөцийн мэргэжилтэн Ш.Сарангээрэл, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн Р.Номиндэлгэр нар очиж ажиллаж, иргэний гомдлыг шийдвэрлэсэн.



1.7. Хүний нөөцийн чиглэлээр:

Ухаалаг төрийн үзэл баримтлалын хүрээнд төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн санг бүрдүүлэх, энэ үндсэн дээр төрийн байгууллагын бүтэц орон тооны оновчтой хувилбар боловсруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй Хүний нөөцийн удирдлага, хяналтын нэгдсэн системд газрын 398 албан хаагчдын бүрэн мэдээлэл шивж оруулсан.

2018, 2019 онд Авлигын эсрэг сургалтанд хамрагдсан болон хамрагдаагүй албан хаагчдын судалгаа, мэдээллийг гарган сургалтанд хамрагдах саналаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж нийт 222 албан хаагч хамрагдсан байна.

Зэрэг дэв ахиулах албан хаагчдын судалгаа, албан хаагчдын хүйсийн судалгааг гарган тус тус Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн.

Төрийн захиргааны 322 албан хаагч ХАСХОМ-ээ шинэчлэн гаргаж өгсөн бөгөөд хугацаа хоцроосон, мэдүүлэхээс татгалзсан хүн байхгүй. Хуулийн хугацаанд ХАСХОМ гаргаж өгсөн тухай мэдээ тайланг УБЕГ-ын ЭБАТ-д хүргүүлсэн. 2019 онд шинээр томилогдсон 30 төрийн захиргааны албан хаагчаас ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулан авсан.

Тайлант хугацаанд тус газрын 285 албан хаагчдын ажлын үнэмлэхний хугацаа сунгах, дахин шинээр олгох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг нэг удаа авсан. Нийт 277 албан хаагч судалгаанд оролцсон. Судалгааны үр дүн, УБЕГ-т удаа дараа аман болон бичгээр хүсэлт тавьсны үр дүнд байгууллагын албан хаагчдын нэг өдөрт ногдох хоол, унааны нөхөх төлбөрийг 2019.04.01-ний өдрөөс 5000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 21, 24 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын цалин, зэрэг дэвийн нэмэгдлийг бодож олгож байна.

Газрын нийт албан хаагчдын хувийн хэргийн баяжилт, мэдээллийг шинэчлэх зорилгоор дараах судалгаа, мэдээллүүдийг нэгтгэсэн. Үүнд:

1. Албан хаагчдын шагнал, урамшууллын судалгаа
2. Хүүхдийн судалгааг гаргуулан нэгтгэж авсан.

Шинээр томиолгдон ажиллаж буй албан хаагчдад төрийн албаны болон улсын бүртгэлийн хууль тогтоомж, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг танилцуулан холбогдох журмын дагуу ажлыг хүлээлцүүлэн тэмдэглэл ажил хүлээлцсэн тэмдэглэлийг бүртгэж ажилласан.

1.8. Сургалт, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах чиглэлээр:

Нийслэлийн улсын бүртгэлийн газрын Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Пүрэвжаргал, Бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Байгалмаа нар нь 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Дүнжингарав, мөн сарын 21-22-ны өдрүүдэд Драгон, Мишээл, Оргил төвийн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд дэх Улсын бүртгэлийн үйлчилгээний ажлын ачаалал, үйлчилгээний стандарт, тулгамдаж буй асуудлын талаар газар дээр нь танилцан, ажиллалаа. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүрэг болон 4 НҮНТ-д ажлын чиглэл, зөвлөмжийг 5 удаа хүргүүлэн ажилласан.

Архивын хэлтсийн ахлах мэргэжилтэн В.Баярцэцэг Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны улсын бүртгэгч М.Цэндсүрэн, Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны улсын бүртгэгч Х.Бүргэдбаатар, Багануур дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Г.Оюунбилэг, Багахангай дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч М.Ариунбаяр нарт иргэний бүртгэлийн мэдээллийн сангаас лавлагаа хэрхэн олгох, “Мэдээлэл удирдах програм” дээр ажиллах талаар ажлын байран дээр сургалт явуулсан ба Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүд, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн чиглэлээр лавлагаа олгож байгаа хороо, дүүргийн улсын бүртгэгч нартай утсаар холбогдож, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрт нь өгч байна.

Харилцагчийн үйлчилгээний хэлтсийн дарга, мэргэжилтэн нар төвийн 6 дүүргийн 14 хороонд очиж ажиллаж хорооны улсын бүртгэгчийн үйл ажиллагаатай танилцан шинэ эрх зүйн орчинд програм хангамж, үйл явц /процес/-ын давхардал болон үйлчилгээний стандарттай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/211 дүгээр тушаалаар батласан “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг байгууллагын цахим хуудсанд байршуулан бүх албан хаагчдад танилцах хуудсаар танилцуулсан.

Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэнд хяналт тавих, Сахилга, хариуцлага дэг журмыг сайжруулах, чангатгах ажлын хүрээнд хэлтэс, нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалт 5 удаа, ажлын цаг ашиглалтын хэрэгжилтийг хангах өглөөний цагийн бүртгэлийг газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд 7 удаа хийж, ажилласан байна.

УБЕГ-ын даргын 2019 оны А/685 дугаар тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг хангах, үйлчилгээний соёл, стандартыг сайжруулах, албан хаагчдын үйлчилгээний стандартад үнэлэлт дүгнэлт өгөх, сайжруулалтын арга хэмжээ авах зорилгоор Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын даргын 2019 оны А/21 дүгээр тушаалаар НУБГ СТ_1, НУБГ СТ_2, НУБГ СТ_3, НУБГ СТ_4, НУБГ СТ_5 маягуудыг боловсруулан батлууллаа.

Мөн уг стандарт батлагдсантай холбоотой сургалтын модуль боловсруулан 3 удаагийн давтамжтай сургалтыг нийт 495 албан хаагчдад /давхардсан тоогоор/ зохион байгууллаа.

Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, албан хаагчдын сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор “Байгууллагын үйлчилгээний стандарт, “ISO 9001-2015 Чанарын удирдлагын менежмент”, “Төрийн албаны үйлчилгээний соёл” сэдвээр 4 удаагийн сургалтыг зохион байгуулснаар 172 албан хаагч хамрагдсан байна.

Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг мэдээллийг сайжруулах зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас 31, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудаас 31, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газраас дүүрэг дэх хэлтсүүдэд 21 удаа, дүүргүүд дэх Улсын бүртгэлийн хэлтсүүд дотооддоо 40 удаа, нийт 123 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 2421 албан хаагч хамрагдсан байна.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдээс дотооддоо зохион байгуулсан сургалт:

НУБГ-ын төвийн 6 дүүргийн нийт 256 албан хаагчдад 2019.03.28-ны өдрийн 18:00 цагт нийслэлийн "ИРГЭНИЙ ТАНХИМ"-д Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих 1 дүгээр хэлтсийн хяналтын прокурор, хууль цаазын ахлах зөвлөх Н.Мөнхцэцэг “Авлига, авлигын болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж өөртөө болон бусдад давуу байдал бий болгох гэмт хэргийн талаар, ёс суртахууныг төлөвшүүлэх” сэдвээр, Нийслэлийн захирагчийн ажлын алба, НОБГ-тай хамтран "Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль" сэдвээр,

Байгууллагын үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, албан хаагчдын сахилга хариуцлага, харилцааны соёлыг дээшлүүлэх зорилгоор Байгууллагын үйлчилгээний стандарт, “ISO 9001-2015 Чанарын удирдлагын менежмент”, “Төрийн албаны үйлчилгээний соёл” сэдвээр 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 172 албан хаагч хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газраас 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 3/2022 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд Прокурорын байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулсан.

“Улсын бүртгэлийн үйлчилгээний стандарт”-ын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүргийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 07-оос 11 дүгээр сарын 19-ны өдрүүдэд Нийслэл дэх газар, 9 дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний 4 төвийн нийт 220 ажилтанд 12 удаа “Байгууллагын үйлчилгээний стандарт - Та бидний оролцоо” сэдвээр сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр дүүргүүдэд очиж, зохион байгуулав.

2019 оны 11 дүгээр сарын 22-нд Хороодын улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэл хөтлөхөд гарч буй алдаа, дутагдал, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн талаарх ойлголт, төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй зэрэг сэдвээр сургалт, хэлэлцүүлэг сургалтыг Азийн сантай хамтран зохион байгуулж хорооны улсын бүртгэгчид бүрэн оролцсон.

Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн багш М.Мөнхбаяр “Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт” сэдвээр тус газар болон хэлтсүүдийн дарга, ахлах улсын бүртгэгч, хяналтын улсын байцаагч нийт 36 албан тушаалтанд сургалт хийв.

Нийслэлийн прокурорын газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж буй “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт видео хичээлийг 2019 оны 9 дүгээр сарын 26-30-ны өдрүүдэд хэлтэс тус бүрээр зохион байгууллаа. Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн нийт 239 албан хаагчид энэ сургалтанд идэвхтэй хамрагдаж, хар тамхи мансууруулах бодисын талаарх ерөнхий ойлголт, хор хөнөөл энэ төрлийн гэмт

хэргээс хэрхэн урьдчилан сэргийлэх, манай улс ямар түвшинд байгааг, ямар ял шийтгэл оногдуулдаг зэргээр ойлголттой болсон гэж үзэж байна.

Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүд дотооддоо 40 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон бусад төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалт:

1. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим, системийн шинэчилсэн хувилбар /EPRS2/-ыг нийслэлийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулах сургалтыг 2019 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан. 2019.01.19-ний өдөр Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн цахим системийн шинэчилсэн хувилбар \ePRS-2\-ыг Нийслэлийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулагдсан сургалтанд улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, мэдээлэл технологийн ажилтнууд хамрагдаж мэдээ мэдээлэл авч ажиллаа.

Тус сургалтад хэлтсийн улсын ахлах бүртгэгч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нар оролцож Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS2/-ын шинэчилсэн хувилбарын давуу тал, түүнийг хэрэглэх нь, дадлагажуулах сургалтад хамрагдсан.

Дээрхи Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS2/-ыг нийслэлийн хэмжээнд 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн бүртгэлийн хэрэглээнд нэвтрүүлээд ажиллаж байна.

2. 2019.01.24-ны өдөр Монгол улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, нийслэлээс “Иргэдийн оролцоотой хөгжлийн жил” болгон дэвшүүсэн зорилтот жилийн хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын зөвлөгөөнд хэлтсийн дарга оролцож мэдээ мэдээлэл авч ажилласан.



3. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад нийт 222 албан хаагч хамрагдсан.

4. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан төрийн захиргааны албан хаагчдад зориулсан “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” сэдэвт нэгдсэн сургалт, 2019.03.25-наас 2019.03.29 өдрүүдэд АТГ-ын олон нийтийн төвөөс зохион байгуулсан Авлигын эсрэг сургалт, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан сургалт, Цахим хороо төслийн сургалтад албан хаагчил хамрагдсан байна.

5. “Jet” англи хэлний сургалтын төвийн анхан, дунд шатны 45 хоногийн сургалтад тус газрын 8 албан хаагч хамрагдаж байна.

6. Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахим хэлбэрт шилжүүлэх, төрийн бүх үйлчилгээг нэгдсэн QR-ын стандартад шилжүүлэх, нэхэмжлэх суурьтай үйлчилгээний төлбөрийг цахимаар төлөх үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд Гааль, татвар, санхүүгийн

мэдээллийн технологийн төв УҮГ-ын дарга Т.Батбилэг, систем төлөвлөлтийн албаны менежер Д.Очирпүрэв, систем шинжээч Г.Тэмүүжин, Мэдээллийн технологийн газрын мэдээллийн сан, програм хангамжийн хэлтсийн програмист Ч.Дэлгэрбаяр нар “e-barimt” аппликейшн ашиглан бүртгэлийн үйлчилгээний төлбөр төлөх талаар”, УБЕГ-ын Улсын бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Т.Байгалмаа, мэргэжилтэн Н.Наранчимэг, мэргэжилтэн Б.Лхагвасүрэн нар нь “Цахим мэдээллийн сангийн ашиглалт, лавлагаа олголт”-ын талаар Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, дүүргийн нийт иргэний улсын бүртгэлийн улсын бүртгэгч нарт 2019 оны 10 дугаар сарын 09-нөөс 11-ний өдрүүдэд сургалт, мэдээллийг олголоо.

7. Тус сургалтанд нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, дүүргүүдийн иргэний улсын бүртгэл хариуцсан 200 гаруй улсын бүртгэгч нар хамрагдаж, нэмэгдсэн өртгийн албан татварын системд суурилсан мобайл аппликейшн ашиглан хэрхэн төрийн үйлчилгээ авах, онлайн төлбөр тооцоо хийх талаар мэдээлэл сонсов.

8. Тахир дутуу иргэдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах анхан шатны харилцааны арга зүй, дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох сургалтыг УБЕГ-ын Тамгын газрын байранд 2019 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд УБЕГ-аас зохион байгууллаа.

9. Уг сургалт Улсын бүртгэлийн ерөнхий газрын "Байгууллагын үйлчилгээний стандарт"-ын хэрэгжилтийг хангах, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх үйлчилгээг хүртээмжтэй болгох, албан хаагчдад хөгжлийн бэрхшээлийн талаарх үндсэн ойлголт өгөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах анхан шатны харилцааны арга зүйг олгох, дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгох хүрээнд зохион байгуулагдсан байна.

10. Сургалтыг дохионы хэлний хэлмэрч, орчуулагч С.Бямбадэлгэр, туслах багшийн хамт хичээл зааж байгаа бөгөөд сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт, сонсголын бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүйн онцлог, дохионы хэлний үүсэл гарал, хурууны хөдөлгөөн, үндсэн байрлал болон практик хичээл багтсан ба Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв /"Мишээл", "Драгон", "Оргил"/ болон дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах улсын бүртгэгч, улсын бүртгэгч нар хамрагдсан байна.

11. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр”-ийн төрийн захиргааны албан хаагчдын “Сургалтын хэрэгцээ, чадамжийн үнэлгээ” судалгааг ERP.ULAANBAATAR.MN хаягаар онлайнаар авсан бөгөөд тус газраас нийт 280 ажилтан хамрагдсан байна.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалт:

Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсүүдээс “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр хэрэгжилт”-ийг хангах ажлын хүрээнд иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг нийт 80 удаа зохион байгуулж, 1235387 иргэд хамрагдсан байна.Тухайлбал:

Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газраас гаргасан хуваарийн дагуу тус хэлтэс нь 4 дүгээр хороог хариуцаж ажилладаг. Энэ ажлын хүрээнд:

Иргэдийн Нийтийн Хурлыг 01 дүгээр сарын 11-ний өдөр хорооны “Иргэний танхим”-д зохион байгуулж хурлыг хорооны иргэдийн нийтын хурлын дарга Т.Найдан удирдан явуулсан. Мөн энэ үйл ажиллагаанд тус хэлтэс нь өөрийн 2018 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан. Тухайн хуралд нийт 77 иргэнд оролцсон.



Улсын бүртгэлийн хаяг цэгцлэх сарын аяны хүрээнд хаягандаа амьдардаггүй иргэдийн хаягийг цэгцлэх талаарх сургалтыг тус дүүргийн хороодын хэсгийн ахлагч нарын ажлын байранд хийж нийт 18 хэсгийн ахлагч нар хамрагдлаа.

2019.01.11-12-ний өдрүүдэд Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Дүүргийн ЗДТГазрын хэлтэс албадуудын хамт шугам замын иргэдэд Улсын бүртгэлийн шинэчилсэн хуулийн талаар мэдээлэл сургалт зохион байгуулж иргэний үнэмлэхээ гээгдүүлсэн 2 иргэний материалыг хүлээн авч ажилласан.

Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 14 өдрийн А/56 дугаар захирамжаар батлагдсан “Явуулын өргөө арга хэмжээ” зохион байгуулах удирдамжийн дагуу 2019 оны 03 дугаар сарын 27-30-ны өдрүүдэд хэлтсийн даргын албан үүргийг орлон гүйцэтгэгч Б.Наранбат, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Э.Одцэцэг, хорооны улсын бүртгэгч нар 7 хороонд ажиллаж, 63 иргэнд улсын бүртгэлийн талаар мэдээлэл, зөвлөгөө, гарын авлага өгч ажилласан.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, нийслэлийн төр захиргааны байгууллагаас “Иргэдийн оролцоотой хөгжлийн жил, тус дүүрэг “Иргэдийнхээ хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, ил тод, нээлттэй хүргэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, төрийн байгууллагын шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн саналыг авч, төрийн үйлчилгээг удирдах, хянах, үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангаж иргэдийн санал хүсэлтийг сонсож шийдвэрлэх зорилгоор “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” аяныг 1, 2, 6 дугаар хороонд нээлт, хаалтын үйл ажиллагаанд тус хэлтсийн дарга Д.Оюунбилэг оролцож, аяны хүрээнд Улсын бүртгэлийн байгууллага болон улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой дараах санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Үүнд:

1. Иргэний шинэчилсэн бүртгэлийг хороон дээр хийж, иргэд цахим үнэмлэхээ хороон дээрээс захиалж авдаг байх.

2. Иргэний үнэмлэх шинээр авах, сунгах хороон дээр үнэмлэхийг захиалдаг баймаар байна.

3. Оршин суугаа газрын хаяг буюу иргэний үнэмлэхний хаяг, эзэмшлийн болон өмчлөлийн газрын хаяг 2 өөр өөр тохиолдолд бүртгүүлж болох уу? Заавал 1 хаягтай байх шаардлагатай юу?

4. Газар бүртгүүлэхтэй холбоотой асуудал

5. Burtgel.mn-ээс бүх төрлийн лавлагаа гарч байгаа талаар

6. Хүүхэд цэцэрлэгт явж чадахгүй байна гэсэн асуултууд ирсэн.

Эдгээр 6 асуудлаас 4 /67%/ асуудлыг газар дээр нь шалган, шийдвэрлэж, 2 /33%/ асуудлыг Хорооны Улсын бүртгэгч иргэний шинэчилсэн бүртгэл хийх боломжтой болгох талаар 2019 оны дүүргийн төлөвлөгөөнд тусгахаар саналаа өгсөн. Мөн 6 дугаар хорооны 1000 иргэний талархлын баярт оролцож, 16 нас хүрч иргэний үнэмлэхээ авч буй 4 иргэнд иргэний үнэмлэхийг ёслол төгөлдөр гардуулан өгсөн.

Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас 2019 оны 05 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд “Инновацын үзэсгэлэн 2019” арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд

Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 48 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд 1900-1950 мэдээллийн лавлахын 73 операторд улсын бүртгэлтэй холбоотой сургалтыг хийв. Тус лавлахын 1 оператор өдөрт дунджаар 300 гаруй иргэнд мэдээлэл, зөвлөгөөгөөр үйлчилгээ үзүүлдэг байна.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг тогтмолжуулах ажлын хүрээнд Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Б.Уранчимэг 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр дүүргийн “Голомт” цогцолбор сургууль, “Эрдмийн оргил” цогцолбор сургууль, 119 дүгээр дунд сургуулийн ахлах ангийн сурагчид, 2019 оны 05 дугаар сарын 16-ны өдөр МСҮТ-ийн оюутнуудад иргэний давхцахгүй өгөгдлийн бүртгэл, иргэний үнэмлэхийн бүртгэлийн талаар сургалт зохион байгуулж, 199 оюутан, сурагчдыг хамруулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх өдөрлөг”-ийн арга хэмжээнд Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Б.Уранчимэг оролцож, иргэдэд улсын бүртгэлийн хууль, тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Улсын бүртгэлийн багц хууль шинэчлэн батлагдсан, хороодод онлайн сүлжээ нэвтэрч улсын бүртгэлийн зарим төрлийг анхан шатны нэгжээр дамжуулан бүртгэж байгаатай холбогдуулан дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын албан хаагч, иргэдэд үе шаттайгаар мэдээлэл хүргэн, сургалт зохион байгуулсан. Дээрх ажлын хүрээнд Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгчид 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр дүүргийн 4 дүгээр хорооны Малчин эмэгтэйчүүдийн II дугаар чуулга уулзалтанд, 2019 оны 05 дүгээр сарын 09-ны өдөр Газар зохион байгуулалтын алба, БНД дэх ШШГ-ын 427-р хаалттай хорих анги, 4 дугаар хорооны алба, иргэд Хилийн инженер техникийн 0252-р тусгай анги, ХААН БАНК” ,“ХАС БАНК”-ны Багануур салбарын нийт 325 төрийн албан хаагч, иргэдэд Улсын бүртгэлийн багц хуулийг сурталчлан, гарын авлага, тараах материал тарааж ажиллаа.

Багахангай Дүүргийн Засаг даргын 10 дугаар сарын 22-ны А\205 дугаар “Явуулын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх тухай” захирамжийн дагуу Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Д.Батдэлгэр дүүргийн өртөө зөрлөгийн дагуу амьдардаг шугам замын иргэд, малчин, мал бүхий айл өрхүүдэд “Явуулын нэг цонхны үйлчилгээ”-г үзүүлж нийт 19 өрхийн 38 иргэдэд бүртгэлийн багц хуулиуд болон шинэ мэдээ мэдээлийг хүргэж ажиллалаа. Мөн Төв аймгийн Баян сумын нутаг дахь ШШГЕГ-ын харьяа 415-р хаалттай хорих анги, СМДӨАЭАХГ-ын 95 ажилтан, албан хаагчдад Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, иргэн болон эд хөрөнгийн бүртгэлийн талаар сургалт, зөвлөгөө өгсөн.

Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд зориулсан эрх зүйн сургалтыг зохион байгуулж нийт 56 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ болон зөвлөгөө мэдээлэл өгч, 7 дугаар хорооны улсын бүртгэгч Д.Ариунтунгалаг 2019 оны 10 дугаар 21-ний өдөр, 5 дугаар хорооны улсын бүртгэгч Б.Дулмаа 2019 оны 10 дугаар 25-ны өдөр хорооныхоо хэсгийн ахлагч нарт "Иргэний улсын бүртгэлийн тухай ойлголт, төрөл, үйлчилгээ" сэдвээр сургалт зохион байгуулж, 12 хэсгийн ахлагч хамрагдсан.

Хан-уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 2019 оны 10 дугаар сарын 7-10-ны өдрүүдэд Спирт Бал Бурам Трейд ХХК-ны 2100 ажилчдад тус коопаниас зохион байгуулсан “Нээлттэй өдөрлөг”-т хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Лхагваханд, 1 дүгээр хорооны улсын бүртгэгч Г.Дашхорол, 2 дугаар хорооны улсын бүртгэгч П.Оюунцэрэн, 3 дугаар хорооны улсын бүртгэгч Б.Ариунтунгалаг нар өдөрлөгт оролцсон 2100 ажилтан,

албан хаагч нарт улсын бүртгэлийн үйл ажиллагаа, иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, 3000 гаруй улсын бүртгэлийн бүрдүүлбэрийг тараан холбогдох сонирхсон асуултанд хариулж ажиллалаа.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн Улсын бүртгэгч нар “Иргэний эрх зүй боловсрол олгох сургалтыг амжилттай зохион байгуулсан бөгөөд 16 нас хүрч буй иргэний үнэмлэх олгож бичиг баримтжуулах, төрийн үйлчилгээгээр Иргэний эрхийг хангах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Ерөнхий боловсролын 15 сургуулийн 1167 сурагчдад “Иргэний эрх зүй олгох сургалт”-ыг амжилттай зохион байгуулж ажилласан. Тухайлбал:

Хан-Уул дүүргийн 15, 75 дугаар дунд сургуулийн 10 дугаар ангийн нийт 137 сурагчдад, Хан-Уул дүүргийн 2, 3 дугаар хорооны улсын бүртгэгч нар хамтран, 52-р сургуулийн 118 сурагчид, 115-р сургуулийн 76 сурагчид 1, 15-р хорооны улсын бүртгэгч нар, 9, 10 дугаар хорооны улсын бүртгэгч нар хамтран 2019 оны 10 дугаар сарын 18-нд 114-р сургууль, “Буянт-Ухаа цогцолбор сургуулийн 9-10 дугаар ангийн 143 хүүхдэд, 6, 7, 8 60 дугаар сургуулийн 132 сурагч, 118 дугаар сургуулийн 106 сурагчид, 13, 14 дүгээр хорооны улсын бүртгэгч нар хамтран 26, 59 дүгээр сургуулийн 11-12 дугаар ангийн 57 сурагчид, 4, 8 дугаар хорооны улсын бүртгэгч нар хамтран 34 дүгээр сургуулийн 140 сурагчид, 5 дугаар хорооны улсын бүртгэгч 41 дүгээр сургуулийн 93 сурагчид, 6, 11 дүгээр хорооны улсын бүртгэгч нар хамтран 32 дугаар сургуулийн 10-11 дүгээр ангийн 93 сурагчид, 12 дугаар хорооны улсын бүртгэгч 10 дугаар сургуулийн дугаар сургуулийн 60 сурагчид сургалт зохион байгуулж, гарын авлагыг тараах материалыг тараан өгсөн.



Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Монгол Улсын иргэний андгай өргөх ёслолын үйл дүүргийн ИТХ, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс хамтран 2019.10.24-ний өдөр нийт 60 гаруй сурагчдад амжилттай зохион байгуулж ажиллалаа. Үйл ажиллагааг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цэрэн нээж мэндчилгээ дэвшүүлж, “Эерэг тэмүүлэл” ТББ-ын сургагч багш “Эерэг харилцаа хандлага, нийслэлийн иргэний 10 зөв дадал” сэдэвт лекцийг Б.Төмөр-Очир сонсголоо

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой нилээдгүй ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд “ШИНЭЛЭГ” хүртээмж сайтай арга хэлбэрийг эрэлхийлэн ажиллалаа. Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс дүүргийнхээ фейсбүүк хуудсаар дамжуулан шууд нэвтрүүлэгт оролцон улсын бүртгэлийн үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл өгсөн. Шууд нэвтрүүлгийн нийт 30 гаруй мянган иргэнд үзэж холбогдох асуултанд хариулсан.

1.9. Нээлттэй хаалга арга, ёслолтой бүртгэлийн арга хэмжээний хүрээнд:

“Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний улсын төсөвт, төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүн танилцуулах үзэсгэлэн, нээлттэй арга хэмжээ”-г 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Уг арга хэмжээнд Нийслэлийн улсын бүртгэлийн газар нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж болон иргэний шинэчилсэн бүртгэл, хаясан гэсэн иргэний үнэмлэхний материал хүлээн авах, иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Нийслэлийн 6 дүүрэг, газар хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч нийт 110 албан хаагч оролцож, нийт үйлчилгээ үзүүлсэн иргэний бүртгэл-22, зөвлөгөө мэдээлэл өгсөн-50, гарын авлага, брошур-96 иргэнд улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан таниулж ажилласан.



Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 3 сарын 22-ны өдөр “Монгол улсын иргэний андгай өргөх ёслол”-ыг Хан-Уул дүүргийн ЗДТГ, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Соёлын ордонтой хамтран 111 хүүхдийг хамруулан зохион байгууллаа.



Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс дүүргийн Иргэдийн Нийтийн Хурлыг 01 дүгээр сарын 11-ний өдөр хорооны “Иргэний танхим”-д зохион байгуулж хурлыг хорооны иргэдийн нийтын хурлын дарга Т.Найдан удирдан явуулсан. Мөн энэ үйл ажиллагаанд тус

хэлтэс нь өөрийн 2018 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан. Тухайн хуралд нийт 77 иргэнд оролцсон.



2019.03.07-ны өдөр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус хэлтсийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Баянгол дүүргийн Гэрлэх ёслолын ордонтой хамтран шинээр гэрлэж буй хосууд болон шинэ төрсөн хүүхдэд төрсний гэрчилгээ авах, 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх гардан авч буй иргэдийг андгай өргүүлэх үйл ажиллагааг ёслол төгөлдөр, хүндэтгэлтэйгээр бичиг баримтыг гардуулан олгох ажлыг зохион байгууллаа.

“Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг угтан 2019 .05.09-ны өдөр Баянгол дүүргийн Гэрлэх ёслолын ордонтой хамтран залуу хосын гэрлэлтийг батлан гэрчилгээ олгон ажилласан. Үүнд БГД-ийн Иргэний бүртгэлийн тасгийн хамт олон нийт 15 залуу хос, 1 шинээр мэндэлсэн нярайн гэрчилгээг ёслол төгөлдөр гардуулсан.

Хэлтсийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан 5 гэр бүлд гэрлэсний гэрчилгээг ёслолтойгоор гардуулах арга хэмжээг зохион байгуулж, хэлтсийн даргын “Батламж” –ийг гардуулсан.

Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс дүүргийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэстэй хамтран 4 дүгээр сарын 29-ний өдөр “Андгай өргөх ёслол”-д 9, 13, 22 хорооны 10 хүүхдийг хамруулан иргэний үнэмлэхийг ёслолтой гардуулж өгөв.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг хороо тус бүр дээр Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдын хурал, Хорооны засаг дарга нартай хамтран 5 дугаарын сарын 10-ны өдрөөс 17-ны өдрийн хооронд тэмдэглэлээ.

266 нярайн төрсний гэрчилгээ, Ахмад болон залуу гэр бүлийн төлөөлөл 116 хосийн гэрлэлтийн гэрчилгээг ёслолтой гардууллаа.

Монгол Улсын иргэний андгайг 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авч байгаа 120 иргэнээр өргүүллээ.

Арга хэмжээнд оролцсон нийт 502 иргэдэд хорооны иргэдийн хурлын төлөөлөгч нар баяр хүргэн өргөмжлөл гарын бэлэг өглөө.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, нийслэлийн 9 дүүргийн Тамгын газрын болон 136 хорооны ажлын байранд “Нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулж, бүх хэлтэс нэгжүүдэд “угтах ажилтан”-г ажиллуулан 968 иргэнд мэдээлэл, заавар зөвлөмж өгч, 1225 иргэнд иргэний, эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, 1878 ширхэг танилцуулга, боршур, тараах материалыг тараан нийт 2193 иргэнд үйлчилгээ үзүүлж, газрын цахим хуудас, хэлтэс нэгжийн нүүр хуудсаар арга хэмжээг сурталчилан ажилласан.



“Нээлттэй өдөрлөг”-өөр байгууллагын үйл ажиллагааг сурталчилан 44 бүртгэлийг ёслолтойгоор гардуулах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс эхний 10 бүртгэлийн үйлчилгээ авсан иргэнд гарын бэлэг, 10 дахь үйлчилчлүүлэгчид 10 жилийн ойн дурсгалын зүйл гардуулсан.



Мөн шинээр иргэний үнэмлэх гардан авч байгаа 10 сурагчдаар Монгол улсын иргэний андгай өргүүлэн, дүүргийн залуу үеийн төлөөлөл болсон 1 хосын гэрлэлтийг бүртгэж, батламж, дурсгалын зүйлс, шинээр төрсөн 2 хүүхдийн төрсний гэрчилгээг, өндөр настан 9 иргэний газрын гэрчилгээг тус тус гэрээр очиж гардуулан өгсөн.



Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр гэр бүл болсон 1 хосод гэрлэлтийн гэрчилгээг батламж, үнэ бүхий дурсгалын зүйлийн хамт, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн анхны бүртгэл хийлгэсэн 2 иргэнд батламж, гэрчилгээ, гарын бэлэг гардуулсан. Мөн СОС хүүхдийн асрамжийн газартай хамтран 4 иргэнийг бичиг баримтжуулснаас гадна огт бичиг баримт аваагүй 18-30 насны иргэдийг бичиг баримтжуулан төрсний гэрчилгээ дахин олгож, иргэний шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэв.



Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр төрсөн 1 хүүхдийн төрсний гэрчилгээг, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс шинээр иргэний үнэмлэх авч буй 15 иргэнд, шинээр гэр бүл болж буй 2 хос мөн шинэ төрсөн 2 хүүхдийн төрсний гэрчилгээг ёслолтой гардуулж өгөв.



Иргэний үнэмлэх, гадаад паспорт, шилжилт хөдөлгөөний бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа олголт, мөн киоск машин болон ebarimt аппликешныг ашиглан бүртгэлийн үйлчилгээний төлбөр төлөх тухай мэдээлэл зөвлөгөө өгсөн.

Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Улсын бүртгэлийн нэгдсэн тогтоолцоонд шилжсэний 10 жилийн ойг угтан Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олны зүгээс “Сайн үйлс”-ийн аян зохион байгуулж тус өдөр үйлчлүүлсэн иргэдэд халуун аарц, чацарганы шүүсээр үйлчилж, дүүргийн 5 хорооны 5 өрхөд 30 шуудай нүүрс, өндөр настай 10 иргэнд гарын бэлэг тус тус гардуулан өгсөн байна.

1.10. Мэдээлэл технологийн чиглэлээр:

1.10.1 Улсын бүртгэлийн ерөнхий газарт EPRS2 буюу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн програмын сургалтанд дүүргийн мэдээллийн технологийн ажилтан нартай хамт хамрагдсан. Энэхүү сургалтаас програмын тохиргоо, EPRS, EPRS2-н ялгаа болон давуу талуудыг танилцуулсан. Дээрх програм нэвтэрсэнтэй холбогдуулж Налайх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст очиж програмын тохиргоог хийж ажиллаа. Мөн Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /Дүнжингарав салбар/-д EPRS2 програмын тохиргоо болон алдааны мэдээллийг хүлээн авч тэмдэглэгээ хийсэн.

Дээрх тэмдэглэлээр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны 16 цагт дүүргийн мэдээллийн технологийн ажилтан болон IT ZONE –ны мэдээллийн технологийн ажилтан нартай хамт зөвшилцөн гарч байгаа алдааны мэдээллийг ярилцаж шийдвэрт хүрч ажиллаа.

2019 оны 01 сарын 16 өдөр Хан-Уул дүүргийн 7 дугаар хороонд дулааны шугам задарч улсын бүртгэлийн ажилтаны тоног төхөөрөмж усанд автсан тул 01 дүгээр сарын 18-нд тус хороонд очиж тоног төхөөрөмжүүдэд үзлэг хийж компьютер мөн компьютерын hard диск шатсанд тухай дүгнэлт гаргасан. Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглах

боломжгүй эвдрэлтэй тоног төхөөрөмжийг жагсаалт гаргаж, дүгнэлтийн хамт Улсын бүртгэлийн ерөнхий газарт тус газрын 1/122 тоот албан бичгээр хүргүүлж ажиллаа.


“УБЕГ Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” сэдвээр сургалтын хэрэгцээний судалгааг байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийт албан хаагчдаас авч нэгтгэн Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн. Судалгаанд УБЕГ, НУБГ 470 гаруй, орон нураг 600 гаруй нийт албан хаагч хамрагдсан.

Тус газар 7777-1980 гэсэн дугаарын 2018 оны 12 сарын 13 өдрөөс эхлэн олон нийтэд зарлаж мэдээлэл өгч эхэлсэн. Энэ хүү дугаар нь автомат хариулагчтай бөгөөд иргэнд чиглүүлж хэрэгтэй мэдээллийг хүргэж байгаа болно. Энэ дугаарын давуу тал нь 77**-**** дугаар, богино (дотуур дугаар) болон Юнителийн дугаартай хэрэглэгчрүү үнэ төлбөргүй залгах бөгөөд бусанд сүлжээнд ярих дагалдах минуутай. Энэ хүү дугаарыг Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст нэвтрүүлэн ажиллаж байгаа. Дээрх дугаарыг ашигласнаар төсөвт сардаа 200-300 мянган төгрөгийн хэмнэлт үүсгэж чадаж байгаа.

1.10.2. Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах чиглэлээр:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, газрын төсөв санхүү, орлого, зарлагын гүйлгээний мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан олон нийтэд мэдээлсэн. Тайлангийн хугацаанд www.nubg.ub.gov.mn сайтанд бүртгэлийн хууль тогтоомж, цаг үеийн мэдээ, мэдээллийг 150 удаа иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар байршуулан ажилласан. Мөн газар хэлтсүүдийн Facebook-ийн хуудсаар дамжуулан цаг үеийн мэдээ мэдээллийг тогтмол байршуулж байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан.

Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга Т.Булгантамир 3 сарын 20-ны өдөр SBN телевизийн “Мэдээллийн цаг” нэвтрүүлгийн шууд ярилцлагаар бүртгэлийн байгууллага болон хэлтсийн үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн.



Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Б.Сувд-Эрдэнэ 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр МҮОНТ-ийн “Олон нийтийн цаг” шууд нэвтрүүлэгт оролцож, эд хөрөнгийн эрхийн улсын бүргэлтэй холбоотой асуудлаар иргэдээс утсаар ирүүлсэн асуултанд хариулсан.



Оргил төв нь Иргэн, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн холбогдох өөрчлөлтийг powerpoint хэлбэрээр улсын бүртгэгчдийн иргэдэд хандсан дэлгэцэнд байршуулан иргэдийг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна. Оргил НҮНТөвийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага өмгөөлөл эрх зүйн товчоотой хамтран сар бүр зохион байгуулдаг “Эрх зүй-таны амьдрал” сэдэвт хууль эрх зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээнд улсын ахлах бүртгэгч Н.Наранцэцэг нь оролцож, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл өгч ажилласан. Мөн монгол HD телевизийн 05.15-ны өдрийн өглөөний шууд нэвтрүүлэгт иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Мөнхгэрэл оролцож төрсний бүртгэлийн талаар мэдээлэл өгсөн.

Мөн Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс иргэдэд өгөх гарын авлага болон мэдээллийн самбарт байрлуулах бүртгэлийн бүрдүүлэх материалуудыг бүгдийг QR кодтой болгосон нь ухаалаг гар утастай иргэд QR кодыг уншуулаад л burtgel.mn хаяг руу шууд нэвтрэн өөрт хэрэгтэй мэдээллээ шууд авах боломжтой болсон.



Ил тодын мэдээллээр оны эцсийн байдлаар шилэн данс, өргөдөл гомдол, хүний нөөцийн холбогдолтой тушаал, тус газрын дарга болон дээр газрын шийдвэр тушаал тогтоолыг цаг тухай бүрт сайтанд мэдээлэлж ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 5.1.17 дахь хэсэгт “Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, цахим хэлбэрт шилжүүлэх замаар төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, цаасгүй, хүнд сурталгүй хүргэж цахим засгийг бодитой хөгжүүлэх”, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.6 дахь хэсэгт “Төрийн үйлчилгээний нэгдсэн програм хангамжийг хөгжүүлж, цахим мэдээллийн нэгдсэн сантай холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” гэж заасныг тус тус үндэслэн www.eservice.ulaanbaatar.mn төрийн үйлчилгээний дэд системийг хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Дээрхи ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх эрх зүйн зохицуулалт, шат дамжлага, баримт бичгийн бүрдэл, төлбөр тооцоо, шийдвэрлэлтийн хугацаа зэрэг иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын

бүртгэлийн 37 нэр төрлийн үйлчилгээний мэдээллийг гаргаж www.eservise.ulaanbaatar.mn санд шивж оруулсан.

1.11.Бичиг баримтжуулах ажлын хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны “Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 137 дугаар тогтоол Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/487 дугаар захирамжийг үндэслэн Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгмийн олон талт үйлчилгээнд хамруулах зорилгоор иргэдийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлын хүрээнд Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, “Зөв амьдрах ухаан” төрийн бус байгууллага, “Хүүхэд залуучууд эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ төсөл” МУЗН, Үндэсний хүмүүнлэгийн байгууллага, Улаан загалтайн хороо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан.

Мөн Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Монгол Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, Монгол улсын Их Хурлын сонгууль болон хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах зорилгоор “Бичиг баримтын зөрчил арилгах” аяны арга хэмжээг Нэг сарын хугацаанд 5, 10 дугаар сард 2 удаа нийслэлийн хэмжээнд зохион байгуулж ажиллаа.

Арга хэмжээний хугацаанд дүүргүүдийн хороодын улсын бүртгэгч, хорооны Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч, зааварлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хорооны хүн, амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сантай тулгалт хийж ажилласан ба нийслэлийн 9 дүүргийн 152 хороодод бүртгэлтэй 385956 өрхийн 1460575 хүн, ам хамрагдахаас 1007246 иргэд хамрагдсан буюу 68,9 хувийн гүйцэтгэлтэй явагдсан байна. Нийт 128443 иргэний зөрчлийг илрүүлснээс 42639 иргэний буюу 33,1 хувийн зөрчлийг арилгуулжээ.

Иргэний баримт бичгийн зөрчил арилгах, баримт бичиггүй иргэдийг бичиг баримтжуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан. Үүнд:

- Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр нийт 280 иргэний бичиг баримтын зөрчлийг арилгаж төрийн үйлчилгээг авах боломжоор хангаж ажилласан.
- Дүүргийн Улаан загалмайн хорооны санхүүжилтээр огт бичиг баримтгүй 31, зорилтот бүлгийн 39 нийт 70 иргэнд:

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран дүүргийн зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулах ажлыг зохион байгуулж, судалгааг гаргаж ажилласан байна.



1.12. Хаягийн зөрчил арилгалтын талаар:

Нийслэлийн улсын бүртгэлийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Монгол Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын хэрэгжилтийг хангах, Монгол улсын Их Хурлын сонгууль болон хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэл ажлыг хангах зорилгоор “Бичиг баримтын зөрчил арилгах” аяны арга хэмжээг Нэг сарын хугацаанд 5, 10 дугаар сард 2 удаа нийслэлийн хэмжээнд зохион байгуулж ажиллаа.

Арга хэмжээний хугацаанд дүүргүүдийн хороодын улсын бүртгэгч, хорооны Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч, зааварлагч нарын бүрэлдэхүүнтэйгээр хорооны хүн, амын судалгаанд тулгуурлан иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сантай тулгалт хийж ажилласан ба нийслэлийн 9 дүүргийн 152 хороодод бүртгэлтэй 385956 өрхийн 1460575 хүн, ам хамрагдахаас 1007246 иргэд хамрагдсан буюу 68,9 хувийн гүйцэтгэлтэй явагдсан байна.

Нийт 128443 иргэний зөрчлийг илрүүлснээс 42639 иргэний буюу 33,1 хувийн зөрчлийг арилгуулжээ.

1.13. Сонгуулийн ажлын хүрээнд:

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дахин сонгууль тус дүүргийн 10, 19 дүгээр хороонд 2019 оны 03 дугаар сарын 23-нд зохион байгуулагдахтай холбогдуулан сонгуулийн бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргуулан ажилласан. Мөн Нийслэлийн бүртгэлийн газрын даргын “Итгэмжлэгдсэн ажилтан ажиллуулах тухай, “Зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах тухай” 2 тушаал гарсан. Сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах, үүссэн нөхцөл байдлыг тухай бүр шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий “Удирдлагын шуурхай баг”, сонгуулийн ирц бүртгэлийн техник тоног төхөөрөмж, програм хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий “Мэдээлэл технологийн шуурхай баг”-ийг тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах, бүртгэлийн хэлтсээс чиглэл хүргүүлэн уирдлага арга зүйгээр ханган ажилласан. Сонгуулийн үеэр бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчил, дутагдал гараагүй болно.

Мөн УБЕГ-ын даргын “Шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоох тухай” А/336 дугаар тушаалыг үндэслэн Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл түр зогсоох болон сонгуулийн бэлтгэл ажлыг хангах талаар чиглэл өгч, итгэмжлэгдсэн ажилтны судалгааг гаргуулан авч, Тагнуулын ерөнхий газарт хүргүүлэн ажиллаж байна.

1.14. Хороо хуваагдахтай холбоотойгоор зохион байгуулсан ажил:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” 25/21 дүгээр тогтоолоор хүн амын тоо, газар нутгийн хэмжээг харгалзан нийслэлийн Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдэд шинээр 17 хороо нэмж байгуулсан.

Уг тогтоолыг үндэслэн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим хороодод гудамжны нэр, дугаар олгох тухай” А/50 дугаар тогтоол, Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Зарим хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийг шинэчлэн батлах тухай” А/35 дугаар тогтоол, Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 23-ний өдрийн “8 дугаар хорооны гудамжны нэр, хаягийн дугаар олгох тухай” 27 дугаар тогтоолууд тус тус батлагдан гарсан. 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим хороодод гудамжны нэр, дугаар олгох тухай” А/50 дугаар тогтоолыг хүчингүйд тооцож А/58 тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 25/21 дугаар тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1/833 дугаар албан бичгээр засаг захиргааны нэгж өөрчлөгдөхтэй холбоотой зардлын тооцоог гарган хүргүүлсэн.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 1/835 дугаар албан бичгээр шинээр байгуулагдах хороонд ажиллах улсын бүртгэгчдийн цалин хөлс, нийгмийн даатгал, ашиглагдах техник тоног төхөөрөмжийн зардлыг төсөвт суулгуулах саналыг тус тус хүргүүлж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 05 өдрийн А/681 дугаар захирамжаар шинээр байгуулагдсан хороодын үйл ажиллагаа, зохион байгуулалтад гарах зардал, үүний дотор иргэдийн шилжилт хөдөлгөөний болон иргэний үнэмлэх, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ сольж олгох, хуулийн этгээдийн бүртгэлийн шилжилт хөдөлгөөн хөтлөхөд шаардагдах нийт **3.146.150.800** төгрөгийг Нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус газар нь Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт хороод шинээр зохион байгуулагдсантай холбоотойгоор хийж хэрэгжүүлэх ажлын 14 заалт бүхий төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 2/964 дугаар албан бичгээр Улсын бүртгэлийн ерөнхий газарт шинээр 17 хороо байгуулахтай холбоотой чиглэл хүсэх тухай, шинээр байгуулагдаж байгаа хороодын улсын бүртгэгчийн ажлыг тухайн дүүргийн хорооны улсын бүртгэгчээр хавсран үүрэг гүйцэтгүүлэхээр судалгаа гарган, саналын хамт 1/991 дугаар албан бичгээр тус тус УБЕГ-т хүргүүлж ажилласан.

Налайх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолуудыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт тус тус хүргүүлсэн байна.

Мөн шинээр зохион байгуулагдсан 17 хороо нь тус бүр хэдэн өрх, хүн амтай, тухайн хорооны хороолол, хотхон, гудамжны нэр хэрхэн өөрчлөгдсөн, насанд хүрсэн болон насанд хүрээгүй иргэний тоон судалгааг дүүрэг тус бүрээр нэгтгэн гаргаж хүргүүлсэн.

1.Иргэний улсын мэдээллийн санд 2019 оны 10 дугаар сарын 11-ний байдлаар бүртгэлтэй шинээр байгуулагдсан 17 хорооны /16 наснаас дээш насны/ иргэдийн мэдээллийг нэрсээр нь гаргуулан авсан. Үүнд:

- ❖ Налайх дүүргийн 8 дугаар хороонд 1664 өрх, 3528 иргэн;
- ❖ Сонгинохайрхан дүүрэгт шинээр байгуулагдсан 11 хороонд 18663 өрхийн 52404 иргэн;

- ❖ Хан-Уул дүүрэгт шинээр байгуулагдсан 5 хороонд 12094 өрх, 28440 иргэн;
- ❖ Нийт 32421 өрх, 84372 иргэн байна.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2019 он 10 дугаар сарын 10-ны байдлаар хуваагдаж байгаа хороонд байршилтай, эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 25048 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 167 газар, газраас бусад үл хөлдөх эд хөрөнгийн нийт 95191 эд хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- ❖ Налайх дүүргийн 2 дугаар хороонд 156 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 2229, нийт 2385;
- ❖ Хан-Уул дүүргийн хуваагдаж байгаа 5 хороонд 996 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 123 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 42607, нийт 43726;
- ❖ Сонгинохайрхан дүүргийн хуваагдаж байгаа 11 хороонд 23896 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 44 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 25140, нийт 49080;

3.Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2019 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар хуваагдаж буй хорооны хаягаар бүртгэлтэй нийт 19927 хуулийн этгээд байгаагаас Налайх дүүрэгт-637, Хан-Уул дүүрэгт-12716, Сонгинохайрхан дүүрэгт 6574 бүртгэлтэй хуулийн этгээд байна.

Тус газар нь 2019 оны 10 дугаар сарын 23-ний өдөр Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт шинээр 17 хороо байгуулагдсантай холбогдуулан улсын бүртгэл хөтлөх тухай, цаашид авч хэрэгжүүлэх саналын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажилласан.

УБЕГ-ын даргын 2019 оны 10 дугаар сарын 22-ний А/1051 дугаар тушаалаар “Хороодын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 25/21 дүгээр тогтоолоор нийслэлд шинээр 17 хороо байгуулагдсантай холбогдуулан Нийслэл дэх улсын бүртгэлийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж, цаашид хийх ажлын талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлыг хэсэг байгуулагдсан.

Ажлын хэсгийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд хийж хэрэгжүүлэх ажлын талаар чиглэл өгсөний дагуу шинээр зохион байгуулагдсан хорооны Засаг дарга нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн иргэний оршин суух хаягийн тоотыг захирамжаар баталгаажуулан 17 хорооны иргэдийн оршин суугаа хаягийн бүртгэлийн судалгааг гаргуулан авч, ИУБГазарт хүргүүлсэн байна.

Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас 2019 он 10 дугаар сарын 10-ны байдлаар хуваагдаж байгаа хороонд байршилтай, эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 25048 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 167 газар, газраас бусад үл хөлдөх эд хөрөнгийн нийт 95191 эд хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- ❖ Налайх дүүргийн 2 дугаар хороонд 156 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 2229, нийт 2385;
- ❖ Хан-Уул дүүргийн хуваагдаж байгаа 5 хороонд 996 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 123 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 42607, нийт 43726;

- ❖ Сонгинохайрхан дүүргийн хуваагдаж байгаа 11 хороонд 23896 өмчлөх эрхийн газар, эзэмших эрхийн 44 газар, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 25140, нийт 49080;

Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2019 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар хуваагдаж буй хорооны хаягаар бүртгэлтэй нийт 19927 хуулийн этгээд байгаагаас Налайх дүүрэгт-637, Хан-Уул дүүрэгт-12716, Сонгинохайрхан дүүрэгт 6574 бүртгэлтэй хуулийн этгээдийн судалгааг гаргаж тус тус УБЕГ-ын дэд даргад /ажлын хэсгийн дарга/ хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргы 2019 оны А/1051 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа хэдий ч дүүргээс ирүүлсэн тогтоол учир дутагдалтай, хаягийн зөрүү алдаатай асуудлууд гарсан учир холбогдох байгуулагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/1192 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь 2019 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн өргөтгөсөн 2 дугаар хуралдаанаас хэлэлцээд холбогдох газруудад хугацаатай үүрэг даалгаврыг өгөөд байна. Газрын кадастрт суурилсан хаягаар хаягийн бүртгэлийг үндэслэн шинээр байгуулагдсан 17 хорооны хаягийн асуудлыг шийдвэрлэхээр ажлаа зохион байгуулаад байна. Одоогоор 17 хорооны хаягийн асуудал шийдэгдээгүй байгаа тул хаягийн бүртгэлд өөрчлөлт орсон иргэн, хуулийн этгээдэд хаягийн лавлагаа өгөх, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт орох ажлууд хийгдээгүй байна.

Тус газар нь Нийслэлийн Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэгт хороод шинээр зохион байгуулагдсантай холбоотойгоор хийж хэрэгжүүлэх ажлын 14 заалт бүхий төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Одоогоор 17 хорооны хаягийн асуудал шийдэгдээгүй байгаа тул хаягийн бүртгэлд өөрчлөлт орсон иргэн, хуулийн этгээдэд хаягийн лавлагаа өгөх, эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлд өөрчлөлт орох ажлууд хийгдээгүй байна.

1.15. Бусад ажил:

Шороон гахай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, ЗДТГ-аас ахмад настнуудад хүндэтгэл үзүүлдэг уламжлалын дагуу 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хорооны Иргэний танхимд 4 дүгээр хорооны ахмад настнуудад хүндэтгэл үзүүллээ.

Энэхүү үйл ажиллагаанд хорооны ИНХ-ын дарга Т.Найдан, Засаг дарга С.Отгонсүрэн, Ахмадын зөвлөлийн дарга Ш.Дашиймаа, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбилэг нар болон хорооны ажилтан, албан хаагчид оролцлоо.



2019.01.21-25-ны өдрүүдэд Нийслэлийн хэмжээнд Иргэдийн оролцоотой өрхийн хөгжлийг дэмжих жил, Дүүргийн хэмжээнд Иргэдийн оролцоотой бүтээн байгуулалтын жил

болсонтой холбогдуулан иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх зорилгоор Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Д.Батдэлгэр 2014-2018 онд цахимаар газар өмчилж авсан хотод амьдардаг иргэдийн газар өмчлөх гэрчилгээг олгох үйлчилгээг Дүнжингарав худалдааны төвийн 1 цэгийн үйлчилгээний төв дээр ажиллан олгосон бөгөөд нийт 66 иргэний өмчлөлийн гэрчилгээг олгож 9 иргэнээс газар өмчлөлийн материал хүлээн авч ажиллаа.

Харилцагчдад мэдээллийг илүү хүртээмжтэй болгох, мөн улсын бүртгэгч, үйлчилгээний албан хаагчдад дэмжлэг үзүүлэх зорилгоор <http://nubg.ub.gov.mn> цахим хуудас дээр тавигдах иргэн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар харилцагчдаас түгээмэл асуудаг асуултуудыг үйлчилгээний заал, хэлтэс нэгжүүдээс нэгтгэн авч, дүгнэлт боловсруулалт хийж байна. Иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны дүнд шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Судалгаанд оролцогчдын 84,62% нь иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ, 26,92% нь эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ, 7,69% нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг авсан байна. Эдгээр иргэд нь дээрх үйлчилгээг 57,69% нь дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс, 38,46% НҮНТ-өөс, 19,23% хорооноос авснаас улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг 61,54% хангалттай сайн гэж үнэлсэн байна.

Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах эрхийг хамгаалахад аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй “их цэвэрлэгээ 90 минут” бүх нийтийн цэвэрлэгээнд газар, хэлтсийн нийт албан хаагчид өөрсдийн хуваарьт газруудыг цэвэрлэсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйл, 31.1 дэх хэсэгт заасны дагуу тус газрын нийт албан хаагчдаас нийт 1,815,000 төгрөгийн хандивыг Нийслэлийн Онцгой байдлын албанд шилжүүлсэн. Багануур, Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон өөрийн дүүрэгтэй нийт 24 мод тарьсан.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн “Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаж, “Бидний эрүүл мэндийн аюулгүй байдал” нэг өдрийг сар бүрийн 09-ний өдөрт товлон газар, хэлтэс нэгж, албан хаагч, иргэдээс эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж буй орчин, нөхцөл байдалд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээ авах үүрэг даалгаврын дагуу сар бүрийн 09-ний өдөр ажлын байрандаа цэвэрлэгээ хийх өдөр болгон зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу 05 дугаар сарын 09-ний өдөр албан хаагчид ажлын байрандаа чийгтэй цэвэрлэгээ хийсэн.

Байгууллагын хэлтэс, нэгжүүдийн ажлын уялдаа холбоо, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан хэрэгжүүллээ. Үүнд:

1. Ажлын зураг авалтыг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн Дүнжингарав, Драгон, Мишээл төвүүдэд хийсэн. Ажлын зураг авалтын дүнгээс харахад нэг албан хаагчид оногдож буй ачаалал их, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээ авахаар ирж буй иргэдийн бичиг баримтын бүрдэл дутуу, үйлчилгээ авахад бүрдүүлэх материалын талаарх мэдээлэлгүй байгаагаас нэг иргэнд 2 удаа үйлчилж байна. Иймд Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйлчилгээ авахад бүрдүүлэх материал, үйлчилгээ үзүүлж буй нэгжүүдийн мэдээллийг шинэчлэн боловсруулсан. Мөн байгууллагын цахим хуудсыг шинэчлэн боловсруулж, иргэдийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

2. Ажлын байрны чиг үүргийн шинжилгээнд үндэслэн, албан хаагчдын өдөр тутам, сар, жилдээ гүйцэтгэгдэг ажлын процессын зураглалыг хийх ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан төлөвлөлтийг зохион байгуулж ажиллаж байна.

Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт байгаа эсэх талаарх санал асуулгыг байгууллагын nubg.ub.gov.mn цахим хуудас, 9duureg@burtgel.gov.mn цахим хаягаар дамжуулан албан хаагчдаас авсан.

Судалгаагаанд оролцсон нийт албан хаагчдын 78 хувь нь эмэгтэй, 22 хувь нь эрэгтэй байсан ба төрийн захиргааны албан хаагч 84 хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 11 хувь, гэрээт болон бусад албан хаагч 5 хувь оролцсон байна.

Судалгааны дүнгээс харахад ажлын байран дахь хууль бус дарамт шахалт болон бэлгийн дарамт байхгүй, хууль бус үйлдэл, эс үйлдэхүйг хэрэгжүүлэхийг шаардаж байгаагүй гэсэн дүгнэлт гарсан. Тайлангийн хугацаанд ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, ялгавартай хандсан үйлдэл гараагүй бөгөөд энэ талаар албан хаагчдаас гомдол санал ирүүлээгүй байна. Ажлын байран дахь дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д тодорхой тусгасан байгаа болно.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1016, 2019 оны “Түүхий нүүрсний тээвэрлэлт хэрэглээнд хяналт тавих тухай” А/1118 дугаар захирамж, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн Ажлын албаны даргын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ, түүний зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих албан тушаалтны хуваарь”, “Нийслэл дүүргийн Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагаанд 24 цагаар хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын удирдамж”-ын дагуу 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн өглөөний 09:00 цагаас 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн өглөөний 09:00 цаг хүртэл Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаярын удирдлаган дор ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 24 цагийн хариуцлагатай зохицуулагчийн үүргийг гүйцэтгэв.

Тус газрын даргын 2019.11.19-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээ, түгээлт, ашиглалтад хяналт тавих Ажлын хэсгийг 16 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаа.

Чөлөөт цаг, спортын арга хэмжээ:

Чөлөөт цаг спортын арга хэмжээг 9 удаа зохион байгуулж, оролцсон. Тухайлбал:

2019 оны 05 дугаар сарын 18 ны бямба гарагт болсон “УЛААНБААТАР МАРАФОН 2019” олон улсын бүх нийтийн гүйлтийн тэмцээнд газар, хэлтсийн 55 албан хаагчид 5 км-ийн зайн төрөлд амжилттай оролцлоо.

Улсын бүртгэлийн багц хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журмын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, илтгэх чадвар, хамтын ажиллагаа харилцааны ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2019.03.22-ны өдөр Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Нэг иргэн, Нэг бүртгэл” сэдэвт парламентын мэтгэлцээнийг зохион байгуулж нийт 11 баг тамирчид оролцсоноос Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн баг тамирчид 1-р, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн баг 2-р, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн баг 3-р байранд шалгарлаа.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 4 дүгээр сарын 30-ны өдөр чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хамт олныг багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулсан Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын дунд гар

бөмбөгийн спортын тэмцээнд 6 баг оролцож цөмийн төлөө өрсөлдөж аврага багаа шалгарууллаа.



Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олныг харилцааг бэхжүүлэх зорилгоор 2019.09.27-нд Хэнтий аймгийн цэнхэрмандал сумын Хар зүрхний хөх нуур руу аяласан.



Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 10 дугаар сарын 04-ны өдөр Ж.Уранцэцэг ахлагчтай 4 дүгээр баг МИС-ийн биеийн тамирын заланд “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг 6 багийн дунд зохион байгуулж хэлтсийн аварга багийг шалгарууллаа.

Улсын бүртгэлийн 79 жилийн ой, нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жилийн ойг угтаж тасгаас төлөвлөсөн ажлын дагуу АХА тэмцээнийг зохион байгуулж ажилласан байна. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж ажилласан байна.



Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсний 10 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан спортын тэмцээнд тус газрын 2 баг тамирчид оролцон эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд хүрэл, эмэгтэй воллейболын төрөлд хүрэл медалийг тус тус хүртсэн амжилттай оролцсон байна

Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор дардас авч 103 тоот өрөөнд байрлуулсан. Мөн номын санг байнгын ажиллуулж эхэлснээр чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна.

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ:

Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд үе шаттайгаар хамруулан ажиллаж байгаа бөгөөд 2019 онд нийт 145 албан хаагчийг урьдчилсан үзлэгт хамруулсан.

- Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “Эрүүл ажлын байр” удирдамжийн хүрээнд бүх хэлтэс нэгжүүдэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой арга хэмжээг зохион байгуулан иргэд, албан хаагчдад зөвлөмж, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.

- Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын 22 албан хаагчийг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр “Амны хөндийн эрүүл ахуй, урьдчилсан сэргийлэх үзлэг” сэдэвт сургалтыг зохион байгуулж, “Индранил” шүдний эмнэлэгийн дарга Б.Жаргалмаа, эрүүл ахуйч Ц.Золжаргал, нүүр амны техникч Б.Нямхорол нар оролцон, албан хаагчдын сонирхсон асуултанд хариулт өгч, урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулсан.

- Элэгний В,С вирусны урьдчилсан үзлэгт Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 34 албан хаагч, Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн 7 албан хаагч,

- Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс АЗИ ФАРМ ХХК-тай хамтран “Эрүүл Монгол аян” нэг өдрийн хөтөлбөрийн хүрээнд 19 албан хаагчдыг үнэгүй оношилгоонд хамруулж, хямдралтай витамин коктейлээр үйлчлүүлсэн.

- Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Эрүүл мэндийн сайдын 2019 А/327 дугаар тушаалаар Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр: “Тэмбүүг устгая” үйл ажиллагааны хүрээнд дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран албан хаагчдыг “Тэмбүү өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” сургалт, шинжилгээнд 13 албан хаагчийг хамруулсан.


- Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс “ЭЛЭГ БҮТЭН ЭРҮҮЛ МОНГОЛ” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2 байгууллагын ажилтан албан хаагчдын дунд төрийн хууль тогтоомжийг сурталчлах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх сургалт, мэдээ мэдээллээр хангах, үр ашигтай хамтран ажиллах талаар 11 дүгээр сарын 18-ны өдөр САНАМЖ БИЧИГ байгуулсан. Энэ санамж бичгийн хүрээнд хэлтсийн бүх албан хаагчид эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан. Мөн элэгний В,С вирусны шинжилгээнд 33 албан хаагчийг хамруулан, вакцинд 15 албан хаагч хамрагдсан.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс 17 албан хаагчийг Элэгний В,С вирусны урьдчилсан үзлэгт хамруулан албан хаагчдын эрүүл мэнд, биеийн хөдөлгөөнийг дэмжих зорилгоор “Самада Иог”-ийн төвд 10 албан хаагчдыг хөнгөлөлттэй үнээр хамруулж, 5 албан хаагч “Эрүүл хооллолт”-ын клубт хамрагдан эрүүл хооллолтын дадалтай болсон бөгөөд хэлтсийн хамт олонд мэдлэгээ хуваалцан ажиллаж байна.

Сайн үйлсийн аян зохион байгуулсан талаар:

Нийслэлийн Засаг даргын орлогчийн 02-03/685 тоот албан бичгийн дагуу “НЭГ ЗҮРХ - НЭГ НИЙСЛЭЛ” аяныг амжилттай зохион байгуулж нийт 66 эмэгтэйчүүд, хүүхдүүдэд өөрсдийн нөөц болоцоогоороо тусламж дэмжлэг, бүртгэлийн үйлчилгээг үзүүлж ажилласан. Тухайлбал: Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд иргэний үнэмлэх захиалгах, лавлгааг өөрсдийн мөнгөөр олгох, Дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран үнэ төлбөргүй үзлэг оношлогоо, эхо-д харуулах эрхийн бичиг-23, 8-16 насны хүүхдүүдийг олон улсын хүүхдийн найрамдал зусланд 3 хоног үнэ төлбөргүй амрах эрхийн бичиг, хамт олны сэтгэл шингэсэн бэлэг дурсгалын зүйлсүүдийг гардуулан өгсөн.





Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Сэтгэлийн дэм” 1000 төгрөгийн аяныг 2019 оны 03 дугаар сарын 01-нээс 07-ны өдрүүдэд зохион байгуулж хандивын хайрцгийг аялуулж, цугларсан мөнгийг зорилтот бүлгийн иргэнд хандивлах хөдөлгөөн өрнүүлж эхний ээлжинд цугларсан мөнгөөр дүүргийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-ноос санал болгосон зорилтот бүлгийн 2 өрхөд эрүүл хоол хүнс хэрэглэхэд нь дэмжлэг үзүүлж хүнсний зүйл авч өглөө.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 2 өрх, тэргэнцэртэй 2 иргэнд нийт 300000 төгрөгийн хүнсний тусламжийг үзүүллээ.

Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Ж.Булгантамир, 17 дугаар хорооны улсын бүртгэгч Б.Лхамноржин нар тус хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн Амаржаргал/УК93103104/-д 25 насны иргэний үнэмлэхийн сунгалтын бүртгэлийг; -Тус дүүргийн 22 дугаар хорооны улсын бүртгэгч Э.Дарьсүрэн 0-14 насны 5 хүүхэдтэй, нөхөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн Б.Пүрэвсүрэн/НТ84020902/-ний гэрлэлтийн бүртгэлийн холбогдох хураамжийг тус тус өөрсдийн мөнгөөр төлж бүртгэсэн.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газраас Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаа сувилгаа шаардлагатай, хүнд өвчтэй хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдаас зарласан “Хайрын хүч 2” хандивын аянд газрын хамт олон идэвхтэй оролцон эцэг эхчүүдийн урласан 50 ширхэг зөөлөн тоглоомыг худалдан авч, сайн үйлсийн аянд нэгдсэн.

Налайх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн нэг бүрийн 2500 төгрөгний үнэ бүхий торыг 5 албан хаагч худалдан авч дэмжлэг үзүүлсэн.

Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрт хамрагдсан айл өрхүүдэд туслах зорилгоор “Хэрэгтэй зүйлээ хэрэгцээт хүнд” нь аян өрнүүлж 90 ширхэг тоглоом, 90 ширхэг хувцас, 99 ширхэг ном цуглууллаа.



Аяны хүрээнд цугласан эд зүйлсийг 9 дүгээр хороотой хамтран хорооны дээр нь Зорилтот бүлгийн 45 өрхийн иргэдэд өгөх өдөрлөгийг 6 дугаар сарын 8-ны өдөр зохион байгууллаа. Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс сайн үйлсийн аян санаачилж шахмал түлш савлаж, олсон орлогоороо хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сайжруулсан түлш авч өгсөн.

ХЯНАСАН:
АРХИВЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГЧ

О.БАТТӨМӨР

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН:

Р.НОМИНДЭЛГЭР